

Батсуурийн Анхбаяр¹, Батшатарын Эрдэнэ¹, Цэрэндоржийн Болорбат¹,

¹Шинжлэх ухааны академийн Археологийн хүрээлэн.
Монгол улс, Улаанбаатар-13330, Энхтайваны өргөн чөлөө,
Шинжлэх ухааны Академийн хүрээлэнгүүдийн нэгдсэн I байр

Дорнод аймгийн Хэрлэн сумын нутаг Адуунчулууны уурхайд хийсэн авран хамгаалах судалгааны үр дүн

2024 оны 09 дүгээр сард Монголын алт ХХК-ийн Дорнод аймгийн Хэрлэн сумын нутагт ашигт малтмалын үйл ажиллагаа явуулж байгаа “Дорнод Мак” нүүрсний уурхайн талбайгаас хүний яс илэрсэн тул яаралтай авран хамгаалах судалгаа явуулж өгөхийг хүссэн албан бичгийн дагуу ШУА-ийн Археологийн хүрээлэнгээс судлаачдыг томилон илгээж, Монгол улсын “Соёлын өвийг

хамгаалах тухай” хуулийг хэрэгжүүлсэн билээ.

Биднийг уурхайн талбайд очиж нөхцөл байдалтай танилцахад ашигт малтмалын талбайн хананаас шанагат машины үйл ажиллагааны явцад хүний гавлын ясны хагархай, далны ясны хугархайн хамт ил гарч доош унасан байв. Өөрөөр хэлбэл, нэгэн эртний оршуулгын дурсгал эвдэгдэж сүйджээ. Тухайн карьерийн хананд оршуулгын



Зураг 1. Хүний яс илэрсэн хэсэг

нүхний толбо, дараас мэдэгдсэнгүй. Шанагат машины жолоочийн ярианаас үзвэл оршуулгын нүх нь өнгөн хөрснөөс доош 1-1,5 метр гүнд байсан бололтой. Түүнчлэн карьерийн дээд хэсгийн ханын ирмэг орчимд дараас чулуу мэдэгдэхгүйн дээр өнгөн хөрсийг 30-50 см гүнтэй нийтэд нь түрж тэгшилсэн тул өнгөн хөрсний анхны байдал мэдэгдэхгүй болжээ (зураг 1).

Уурхайн зүүн өмнө талд 1 км зайд Баяннуур хэмээх том нуур бий. Нуурын эргээс уурхайн талбай хүртэл налуу өндөрлөг тул уурхайгаас орчны байдал нэлээд тодорхой харагдана. Иймээс уурхайн талбайн захаас нуурын эрэг дагуух налуу энгэрт эртний оршуулгын дурсгалт газар байх боломж өндөр байна (зураг 2). Харин ойр орчимд хад чулуугүй байгалийн тогтоцоос шалтгаалж оршуулгууд шороон дараастай үйлдэгдсэн бололтой.

Олдворын тодорхойлолт.

Гавлын ясны зүүн талын чамархайн яс салж, тусдаа болсон байх ба зүүн хөмсөгний төгсгөл хэсгээс нүдний аяга, хамрын ясыг дайруулан баруун талын хацар ясны дунд хэсэг хүртэл ташуулдуулан цавчсан мэт гэмтэлтэй бөгөөд энэ нь шинэ байгаагаас үзэхэд хожим механик аргаар

үүссэн бололтой. Уг гэмтлийн улмаас гавал ясны зүүн талын хамар, зүүн нүдний аяганы доод хэсэг тагнай, суурь яс үгүй болжээ. Баруун талын дал бүтэн хэдий ч доод өнцөг хэсэгт бага зэрэг эвдрэлтэй байгаа нь мөн шинэ байгааг харвал хожим үүссэн байна.

Өргөн навтгар хамар, өргөн шанаа зэрэг монгол хэв шинжийг агуулсан төрхтэй хүн бөгөөд гавал ясны заадлын бэхжилт хийгээд ерөнхий байдлаас үзэхэд нас биед хүрсэн том хүн байх ба түүшинт хэсэг шүд байхгүй тул насалсан байдлыг нарийн тогтоох боломжгүй. Хөхлөг сэртэн хөмсөгний нумын хөгжлөөс харахад эрэгтэй хүн болох тодорхой байна.

Бидэнд байгаа гавал болон далны ясан дээр бэртэл гэмтэл, ямар нэгэн өвчлөлийн шинж, ул мөр ажиглагдсангүй. Гавал ясны эвдрэлээс болж бүтэн хэмжилт хийх боломжгүй байна.

Үр дүн

Бид уурхайн талбайгаас хүний ясыг авчирч ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн сан хөмрөгт шилжүүлж, улмаар ясны дээжийг Япон улсын Institute of Accelerator Analysis Ltd-д он цаг тогтоох лабораторийн шинжилгээнд явуулахад $2,220 \pm 26$



Зураг 2. Баяннуурын баруун хойд эрэг, уурхайн талбай




Зураг 2. Гавлын ясны хагархай



Зураг 3. Далны яс

буюу 384BC-200BC жилийн өмнөх үед холбогдох нь тодорхой болсон. Энэ нь одоогоос 2220 орчим жилийн өмнө орчим буюу нийтийн тооллын өмнөх 384-200 оны хооронд холбогдоно. Өөрөөр хэлбэл, хүрэл зэвсгийн хожуу үеийн дөрвөлжин булшны соёлын төгсгөл болон Евроазийн анхны төрт улс Хүннү улс байгуулагдсан цаг үед таарч байгаа юм.

Манай улсын нутагт буй дөрвөлжин булшны тархац нь Монголын дорнод нутагт өргөн хүрээг хамардаг. Гадаад зохион байгуулалтын хувьд чулууг хавтгай талаар нь газарт шигтгэн дөрвөлжин хүрээлээд дунд нь чулуу чигжин дараас үйлддэг байна. Дотоод зохион байгуулалтын хувьд дараасын доор 1-1,5 метрийн гүнд хүнээ оршуулдаг аж. Харин хүннүгийн үеийн энгийн иргэдийн булш нь дундажаар 1-3 метр гүнд нүх ухаж талийгчийг оршуулаад, өнгөн хөрсөн дээрээ дунд зэргийн хэмжээтэй чулуугаар цагирган хэлбэртэй дараас үйлддэг. Гэвч хүний яс олдсон талбайгаас ямар нэгэн булшны дараас болон хашлага чулуу огт илрээгүй тул тухайн үед нас барагчийг оршуулахдаа орчин тойронд нэгэнт хад чулуугүй тул орон нутгийн онцлогтой шороон дарааст оршуулга байсан бололтой хэмээн үзэх санал дэвшүүлж байна.



Цаашид газрын хөрсөн дээр ил мэдэгдэх гадаад зохион байгуулалтгүй (*Шороон дараастай булш, газар сууц гэх мэт*), хөрсний гүнд хадгалагдан үлдсэн археологийн дурсгал байхыг үгүйсгэхгүй тул уурхайн ажилтнууд анхаарал болгоомжтой ажиллана уу. Хэрэв дахин соёлын өв илэрсэн тохиолдолд бидэнд мэдэгдэх, улмаар нарийвчилсан судалгаа хийлгэх шаардлагатай юм.

Талархал

Талбайд илэрсэн дурсгалын тухай мэдээллийг шуурхай ирүүлэн, судлаачдыг ажиллах нөхцөл бололцоогоор хангаж, улмаар лабораторийн дээжийн төлбөрийг өөрийн хөрөнгөнөөс хариуцан

гаргаж, Соёлын өвийг авран хамгаалах ажилд идэвх санаачлагатай, нийгмийн хариуцлагыг бусдад үлгэрлэн үзүүлж буй “Монголын Алт” ХХК-ийн удирдлага, нийт ажилтнуудад гүнээ талархал дэвшүүлье.



Open Access This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution

Non Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, adapt, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial.

See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>